



ЗАВХАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/333

Улиастай

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.10, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 215 дугаар тогтоолоор батлагдсан “Цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний тоо бүртгэл хөтлөх, мөнгөн төлбөрийг төлөх, хураан авах, төлбөрийн орлогыг зарцуулах журам”-ийн 4 дүгээр зүйл 4.1.8 дахь заалтыг үндэслэн Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/258 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, бүрэн дунд сургуулийн сурагчдыг цэрэг-эх оронч үзэлтэй, бие бялдар, сэтгэл зүйн өв тэгш хүмүүжил олгох зорилтын хүрээнд бүрэн дунд сургуулийн сурагчдын дунд зохион байгуулагдах улсын аварга шалгаруулах “Дөл” тоглолтод аймгаас шалгарсан нэг тасаг /сургууль/-ийг зохион байгуулан оролцуулсугай.

2. Тэмцээний бэлтгэлийг хангаж, оролцоход шаардагдах 3543764 /Гурван сая таван зуун дөчин гурван мянга долоон зуун жаран дөрвөн төгрөг/-ийг хавсралтаар баталж, цэргийн мөнгөн төлбөрийн орлогоос гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Ж.Хүрэлбаатар/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /дэд хурандаа Г.Нэмэхбаяр/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс /Н.Бямбадорж/-т даалгасугай.

ДАРГА

Д.БАТСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2017 оны 09 дугаар сарын 11-ний өдрийн А/333 захирамжийн хавсралт

УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ “ДӨЛ” ТОГЛОЛТОД ОРОЛЦОХ
БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО

Д/д	Зохион байгуулалтын зардал	Тоо хэмжээ	Нэгж өртөг /төг/	Дүн /төг/
1	ШТМ-ын зардал /Улиастай-УБ-Улиастай/	Фургон А80 980км*2ш*2=1960 км	А80 1680	1251264
2	Байр, хоол	18 хүн*10 өдөр	5000	900000
3	Томилолт	5 хүн*7 хоног	35500	1242500
4	Бусад зардал /Ялгах тэмдэг, дарцаг, аймгийн туг, ханын сонин бэлтгэх зардал г.м/		150000	150000
5	Нийт дүн			3543764

ЦЭРГИЙН ШТАБ